

**“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
2023 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Улаанбаатар хот

2026 оны 04-р сарын 29 нд

Хурал эхэлсэн цаг: 11.10

Хурлаар хэлэлцсэн асуудлууд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан
3. 2026 оны зорилт, төлөвлөгөө
4. Ногдол ашгийн тухай

Хурлын явц:

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Нарантуяа хурлын дэгийг танилцуулав.
Хурлын дэгтэй холбоотой санал хэлэх хүн байна уу?
Хурлын дэгтэй холбоотой санал өгөх хүн **Байхгүй** хурлын дэгийг батлав.

ХЗБ комиссын дарга: Тооллогын комиссын даргаар О.Оюунжаргалыг сонгох саналтай байна, Та бүхэн саналаа хэлнэ үү?

Санал нэг байгаа тул Тооллогын комиссын даргаар О.Оюунжаргалыг томилохыг 100 хувийн саналаар зөвшөөрлөө. Тогтоол № 01-ийг уншиж танилцуулав.

Хурлын ирц: Хувьцаа эзэмшигчдийн хуралд ҮЦГХТ ХХК- иас 2026 оны 04 дугаар сарын 10-ны өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт **12,545,061** ширхэг хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсон нь саналын эрхтэй нийт **15,869,233** ширхэг хувьцаанаас **79,05 %** болсон тул хурал хүчин төгөлдөр болсон. Тооллогын комиссын тогтоолыг № 02 танилцуулав

Нийт хувьцааны тоо	15 869 233
Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо
Ц.Чингүүнболд	1 824 000
Ц.Оргилболд	912 000
Б.Осолгүйгэрэл	30 000
С.Баярцэцэг	6 000
Б.Нарантуяа	4 281 920
Б.Цогтгэрэл	3 548 345
“БиДиСек ҮЦК” ХК	1 260 990
“Тасган инвест” ХХК	653 730
Б. Батцэнгэл	28 076
Нийт ирсэн нь	12 545 061

Б.Нарантуяа: За хурлын дэгийн дагуу хурлын даргыг сонгох ёстой, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Цогтгэрэлийг сонгох саналтай байна?

Эсрэг саналтай хүн гараагүй тул 100 хувийн саналаар Б.Цогтгэрэлийг ХЭХ-ын даргаар сонгов. Тогтоолыг № 03 уншиж танилцуулав.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлын дарааллаар Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулна.

/хурлын материал тараагдсан/

Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа: Өнгөрсөн онд шинээр ажил эхлээгүй. Харин 2018 оноос хойш гүйцэтгэж буй "Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан баруун дүүргийн насос станц хүртэлх 8070 метрийн урттай Ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил"-ыг 12 сарын 29-ний өдөр улсын комисс ажиллуулж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авлаа. Үргэлжлүүлэн хлортой усаар угаах туршилт тохируулгын ажил үлдсэн байгааг энэ 2026 онд гүйцээн хийж УСУГ-т хүлээлгэн өгнө. Санхүүгийн хувьд өмнөх жилүүдэд буюу 2014-2017 онуудад ажил гүйцэтгээгүйн улмаас хуримтлагдсан өр, төлбөр ихтэй, алдагдлаа нөхөх боломж гарахгүй байгаа тул аливаа тендерт оролцох шалгуурыг хангахгүй байна, нөгөө талаас ажилтай байхын тулд мөн тендэрт ялахын тулд хамгийн доод үнэ өгдөг түүндээ шатаад дуусдаг юм байна.

Ер нь хэд хэдэн нөхцөл шалтгааны улмаас сүүлийн 15 жил ашиггүй ажиллаж иржээ. Үүнд:

1. Барилга, дэд бүтэц, эрчим хүч, төмөр зам авто тээврийн салбаруудаас төсвийн ажлын үнэлгээ хамгийн бага нь манай шугам сүлжээний угсралтын ажил байна.
2. Төрөөс авсан ажлын санхүүжилт тухайн жилийн улсын төсөвт бүрэн суудаггүй он дамнуулан хуваагдаж тавигддагаас явцын зардал өсдөг, харин гэрээний үнэ өөрчлөгддөггүйгээс алдагдал үүсэх 1 шалтгаан болдог.
3. Зураг төсөв нь олон жилийн өмнө хийгдээд бодит гүйцэтгэл нь 5-10 жилээр хоцорч зарлагдаад гүйцэтгэхэд цаг хугацааны хувьд болон үнийн өсөлт, инфляци, газар чөлөөлөлтийг хүлээх зэрэг гүйцэтгэгч урьдчилан харах төлөвлөх боломжгүй хүндрэлүүд үүсч байна.
4. Зөвхөн төрийн худалдан авалтаас ажил олж хийж ирсэн нь компанийн хувьд төрөөс хамааралгүй өсч дэвжих боломжийг хязгаарласан.

Өмнөх жилүүдэд хуримтлагдсан өр төлбөрүүд дээр жилээс жилд НӨАТ, нийгмийн даатгалын шимтгэл, бусад татварууд, зээлийн хүүний дарамтаас гарч чадахгүй, санхүүгийн хувьд зээлээс зээлийн хооронд компани мөнгөн хуримтлал үүсгэх боломжгүй явж ирлээ. Намайг 2018 оны 08 сарын сүүлээр захирлаар томилогдоход компани кассандаа ч, дансандаа ч нэг ч төгрөггүй дан ганц тамга л хүлээж авсан, компани дандаа зээлийн санхүүжилтээр ажил гүйцэтгэж, ашгаараа зээлийн хүүгээ төлж ирсэн юм билээ. Тэгэхэд Тасганы төслийн түншлэлийн ажил эхэлсэн байсан бөгөөд манай компани өөрийн хариуцсан трассын шугам угсралтын ажлыг 90 хувьд хүргээд угсралт суурилуулалтыг гүйцэтгэж байсан ч COVID-19 дэлхий дахиныг хамарсан цар тахлын улмаас ажлыг зогсоосон. Харин түншлэлийн компани 2022 он-2024 онуудад ажлаа дуусгасан. Гэтэл бид хөөцөлдөж байж 2025 онд улсын комисс ажиллуулж байна. Зөвхөн энэ төслөөс харахад л дэд бүтцийн ажил гүйцэтгэгчээс хамаарахгүй хөндлөнгийн шалтгаанаар олон жил сунжирдаг нь ойлгомжтой байгаа юм. Мөн ажиллах хүчний ихэнх нь тэтгэвэрт гарсан ахмадууд байсан, техник тоног төхөөрөмж нь ихэнх нь оросын хуучны тээврийн хэрэгслүүд байсан тул насжилт өндөртэй, хугацаа нь дуусч элэгдэлд орсон зэрэг хүчин зүйлүүд ч бас нөлөөлсөн. Ингээд цаашид компанийн үйл ажиллагаа эрхлэх чиглэлийг өөрчлөхгүй бол олон “Би чадна”-чууд болон дарга нарын цүнхний компаниудтай өрсөлдөх боломжгүй мөн татварын дарамтаас болж үнэндээ ажиллах боломжгүй байна.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: Гүйцэтгэх захирлын 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сонслоо. Өнгөрсөн жилийн үйл ажиллагааг гүйцэтгэлийн хувьд “хангалттай” гэж ТУЗ дүгнэсэн. 2025 онд мөнгөн хөрөнгийн ашиглалт, банкны зээл төлөлт, зээлийн хүүг бууруулах болон авлага өглөгийг барагдуулах буюу эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд амжилттай ажилласан байна. Иймд санхүүгийн үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэсэн.

Мөн хуралд хөндлөнгийн хяналтаар Гроут финанс аудит ХХК-ийн Э.Нарангэрэл аудитор ХЭХ-д оролцож байна.

Хувьцаа эзэмшигчдээс үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөх болон цаашид хэрхэх талаар санал хэлэв.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: За өөр асуулт байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудал 2026 оны төсөв, төлөвлөгөөг танилцуулах уу?

Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа 2026 оны төсөв, төлөвлөгөөг танилцуулав.

Хурлын дарга: Та бүхнээс энэ асуудалтай холбоотой асуух зүйл байна уу?

2026 оны төсөв төлөвлөгөөг батлах уу?

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар ХЭХ-аас 2026 оны санхүүгийн төсвийг баталлаа.

Хурлын дарга Б.Цогтгэрэл: -Дараагийн хэлэлцэх асуудал ногдол ашгийн тухай.
2025 оны компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотойгоор ТУЗ-ийн
2026 оны 02 дүгээр сарын 09-ний өдрийн ТУ326/001 тоот тогтоолоор Ногдол ашиг
тараахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

-Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэв.

-Компанийн 2025 оны санхүүгийн үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж
дүгнэв.

-Компанийн 2026 оны зорилт, төлөвлөгөөг батлах

-Компани 2025 онд Ногдол ашиг тараахгүй байх

Хурал 12.10 цагт дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

ХУРЛЫН ДА



Б.ЦОГТГЭРЭЛ

Хурлын тэмдэглэл

УЛААНБААТАР

О.ОЮУНЖАРГАЛ